



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/674

Булган сум

**“Амар тайван Булган” хөтөлбөрийн зардлаас
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөр", "Хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай" Аймгийн Засаг даргын 2025 оны А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс эмхэтгэн хэвлүүлж байгаа "Аймаг, сум, багийн Засаг дарга нар, төрийн албан хаагч нарт зориулсан хуулийн эмхэтгэл" ном хэвлүүлэх, Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа "Мал мах-2025" хэсэгчилсэн арга хэмжээний зардал, согтуурах, мансуурах донтой этгээдүүдийг албадан эмчлүүлэх зардалд нийт 12,100,000 (арван хоёр сая нэг зуун мянга) төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталж, "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

0325010961

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 24-ний өдрийн
А/624 дугаар захирамжийн хавсралт

“АМАР ТАЙВАН БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛААС САНХҮҮЖҮҮЛЭХ АЖИЛ,
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгө зарцуулах зориулалт	Зохион байгуулах нэгж	Хэмжээ	Мөнгөн дүн (төгрөг)
1	2	3	4	5
1	Засаг дарга нар, төрийн албан хаагчдад зориулсан хуулийн эмхэтгэл ном хэвлүүлэх	Хууль эрх зүйн хэлтэс	200 ширхэг А4 хэмжээтэй 1 ширхэг 28,000 төгрөг	5,600,000
2	Мал мах-2025 хэсэгчилсэн арга хэмжээ	Цагдаагийн газар	2 сарын хугацаанд хяналтын пост ажиллуулахтай холбогдон гарах зардал	3,000,000
3	Согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчилгээнд явуулах зардал	Цагдаагийн газар	Согтуурах мансуурах донтой этгээдүүдийг албадан эмчлэх шүүхийн шийдвэр гарах хүртэлх зардал	3,500,000
	Дүн	1 хэлтэс, 1 газар	Ном 200 ширхэг Хяналтын пост 10 ширхэг	12,100,000